



ЭРСДЭЛГҮЙ ИРЭЭДҮЙН БАТАЛГАА

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Огноо: 2023.12.01

№ 93

Улаанбаатар хот

### “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар явуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх хэсэг, 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 65 дугаар зүйлийн 65.1, 65.4 дэх хэсэг, 67 дугаар зүйлийн 67.1, 67.5 дахь хэсэг, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь хэсэг, 73 дугаар зүйлийн 73.1, 73.3 дахь хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан Хувьцаат компанийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал (цаашид “Хурал гэх”) -ыг эчнээ санал хураалтаар явуулсугай.

2. Эчнээ санал хураалтын саналын хуудсыг хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх өдрийг 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдрөөр, хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсыг хүлээж авах сүүлийн өдрийг 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөр тус тус тогтоосугай.

3. Эчнээ санал хураах тухай мэдэгдлийг 2023 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Монголын Хөрөнгийн Биржид тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Э.Уянга)-д даалгасугай.

4. Эчнээ санал хураах тухай зарыг “Төрийн банк” ХК, Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёроос доошгүй сонин, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2023 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д даалгасугай.

5. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудалд санал өгөх саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2023 оны 12 дугаар сарын 22-ны өдрөөр тогтоосугай.

6. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлын жагсаалт, шийдвэрийн төсөл, саналын хуудсыг 2023 оны 12 дугаар сарын 11-ний өдөрт багтаан үнэт цаасны брокер дилерийн компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д даалгасугай.

7. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлын жагсаалтыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

8. Эчнээ санал хураах тухай зарын загварыг 2 дугаар хавсралтаар баталсугай.

9. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг 3 дугаар хавсралтаар баталсугай.

10. Эчнээ санал хураалтын саналын хуудасны загварыг 4 дүгээр хавсралтаар баталсугай.

11. Эчнээ санал хураалтыг зохион байгуулах комиссыг 5 дугаар хавсралтад заасан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

12. Эчнээ санал хураалтын тооллогын комиссыг 6 дугаар хавсралтад заасан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

13. Эчнээ санал хураалтыг зохион байгуулахад шаардлагатай технологийн орчныг бүрдүүлж ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ө.Гантөр)-д даалгасугай.

14. Хувьцаа эзэмшигчдийг холбогдох материалтай танилцах нөхцөл, боломжийг бүрдүүлэх, шаардлагатай мэдээллээр хангаж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг зохион байгуулах комисс (Д.Сугар)-т даалгасугай.

15. “Төрийн банк” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга (Б.Тэлмүүн)-ыг томилсугай.

16. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал, шаардлагатай бусад материалыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, холбогдох бусад журамд заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо, Монголбанк, Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга (Э.Уянга)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ТЭЛМҮҮН